



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 11 сарын 14 өдөр

Дугаар А/301

Алтай хот

Газрын талбайн хэмжээ өөрчлөх  
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хот байгуулалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.5 дахь хэсэг, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Алтай хотын инженерийн байгууламж бүхий бүсэд эзэмшил газрын талбайн хэмжээ өөрчлөх хүсэлт ирүүлсэн "Юнайтэд бест ойл" ХХК-ийн эзэмшиж байгаа газрын хэмжээг өөрчлөн 1-2 дугаар хавсралтаар баталж эзэмшүүлсүгэй.

2.Газар эзэмшсэн "Юнайтэд бест ойл" ХХК-ийн мэдээллийг Газрын удирдлагын нэгдсэн системд холбогдох журмын дагуу бүртгэн баталгаажуулж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Д.Алтанзагас)-т зөвшөөрсүгэй.

3.Газар эзэмшигч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж буй байдалд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар (Н.Сумъяабазар)-т даалгасугай.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2017 оны А/367 дугаар захирамжийн дээрх аж ахуйн нэгжид холбогдох хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА




О.АМГАЛАНБААТАР



**ЮНАЙТЭД БЕСТ ОЙЛ ХХК ( 5892716 ) - ИЙН  
ЭЗЭМШИХ ГАЗРЫН БАЙРШЛЫН КАДАСТРЫН ЗУРАГ**

Нэгж талбарын дугаар: 820800.....  
Хаяг: Говь-Алтай аймаг, Есөнбулаг сум, Жаргалант баг

20... оны ... дугаар сарын ...-ны өдрийн  
... дугаар захирамжийн ...-р хавсралт



Хашааны координат:

Дугаар	X	Y	Урт	Цэгийд
1	5139873.246	287440.682	50.00	1-2
2	5139891.709	287394.216	9.17	2-3
3	5139883.183	287390.828	24.00	3-4
4	5139892.048	287368.524	35.97	4-5
5	5139870.242	287339.920	42.53	5-6
6	5139854.536	287379.445	50.00	6-7
7	5139836.073	287425.911	40.00	7-1

Талбайн хэмжээ: 3025.4 квадрат метр

Зургийн масштаб 1:1 000 (1 сантиметрт 10 метр багтана)